



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ШАРГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2016 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/34

Баянгол

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Монгол Улсын Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалын “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.3 дахь заалт, Засаг даргын зөвлөлийн 2016 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 03 тоот хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын галзуу болон халдварт өвчний дуудлага, устгалд зарцуулсан шатахууны үнэ 455800 төгрөг, Нутгийн мэдээ сонин хэвлэх зардалд 550000 төгрөг нийт 1005800 төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргаж зарцуулахыг санхүүгийн албаны дарга /Н.Гэрэлмаа/, нягтлан бодогч /Л.Оюунбилэг/ нарт зөвшөөрсүгэй.

3. Холбогдох тооцоог хавсралтаар гарган санхүүгийн анхан шатны баримтыг бүрдүүлэхийг нярав /Б.Гэрэлт-Од/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.ТУНГАЛАГТАМИР

C/barimt/zahiramj/2016

00700073